

**ШУУД АРДЧИЛАЛ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГООР ДАМЖУУЛАН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛААР ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн М.Батчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төсвийн төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын иргэд орон нутгийн болон улсын хэмжээнд бие даан шийдвэр гаргахад оролцох, улс төрийн болон эдийн засгийн шийдвэр, гүйцэтгэлийн үйл ажиллагааг хянахад иргэдийн оролцоог хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын үүднээс энэхүү үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Р.Гончигдорж нар дэмжиж үг хэллээ. Хөтөлбөрийн нэрийг Шууд ардчилал шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах замаар төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөр гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт хөтөлбөрийг Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.

Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төсвийн төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төсвийн төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

**А.БАКЕЙ**

